



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2014 оны 02 сарын 16 өдөр

Дугаар Н/23

Улаанбаатар хот

「 Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний  
чиглэлийн замнал, эргэлтийн хугацаанд  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Автотээврийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3, 3.1.19 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баянгол дүүргийн 22 дугаар хорооны иргэдийн зорчих эрэлт, автозамын нөхцөл байдлыг судалсан судалгааны дүнд үндэслэн ТШ:7 “БГД-ийн 10-р хороо-Хасбаатарын гудамж” чиглэлийн замналд өөрчлөлт оруулж нэгдүгээр хавсралтаар, нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж буй чиглэлүүдийн эргэлтийн хугацаанд хийсэн судалгааны дүнд үндэслэн Ч:33 “Шархад-7 буудал-Зунжин худалдааны төв” чиглэлийн эргэлтийн хугацааг өөрчлөн хоёрдугаар, Ч:39 “Сансар-3,4 дүгээр хороолол” чиглэлийн эргэлтийн хугацааг өөрчлөн гуравдугаар, Ч48 “Зүүн салаа-Чингэлтэй дүүрэг-МУБИС” чиглэлийн эргэлтийн хугацааг өөрчлөн дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх чиглэлийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн цагийн хуваарийг боловсруулж 2017 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс үйлчилгээг эхлүүлэн нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/, тухайн чиглэлийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, шуурхай зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулах, ажиллах цагийн хуваарийн мөрдөлтөнд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын хэлтэс /С.Нямдорж/-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Нийслэлийн тээврийн газрын 2014 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/28 дугаар тушаалын 7 дугаар хавсралт, 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/25 дугаар тушаалын 39, 45, 54 дүгээр хавсралтуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ОТГОНБААТАР

